



**ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН 2010 ОНЫ
ЖИЛИЙН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

ГАРЧИГ

1. ОНХТХХ-ИЙН АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД
2. ОНХТХХ-ИЙН ҮНДСЭН ХӨТӨЛБӨРҮҮД
 - ОРОН НУТАГ, БҮСИЙН ТӨЛӨВЛӨЛТ БА ДЭД БҮТЦИЙН ХӨТӨЛБӨР
 - ОРОН НУТГИЙН БИЗНЕС, ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭН ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР
 - СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨР
 - ОРОН НУТГИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХӨТӨЛБӨР
 - ОРОН НУТГИЙН ОРОЛЦООТОЙ БАЙГАЛЬ ОРЧИНЫГ ХЯНАН ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР
3. БУСАД ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР
 - ЭМЧИЙН ОРОН СУУЦ ХӨТӨЛБӨР
 - ЭМЧИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР
 - ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР
4. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН АРГА ХЭМЖЭЭ
5. САЛБАР ОФФИСЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
6. ХАНДИВ, ТУСЛАМЖ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. ОНХТХХ-ИЙН АЛСЫН ХАРАА, ГОЛ ЗОРИЛТУУД БОЛОН БҮТЭЦ

ОНХТХХ-ИЙН АЛСЫН ХАРАА

ОТ төсөл нь Өмнөговь төдийгүй Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжилд ашиг тустай, удаан хугацааны хувь нэмэр оруулна.

ОНХТХХ-ИЙН ЗОРИЛГО

Орон нутгийн харилцаа, тогтвортой хөгжлийн хэлтэс нь Оюу Толгой төслийн үр шимийг Монголчуудад, тэр дундаа Өмнийн говийн иргэдэд бодитойгоор, урт хугацаанд хүргэхийн төлөө хамтран ажиллана. Энэхүү хамтын ажиллагаа нь Оюу Толгой төслийн зорилт болон Монгол улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан стратеги дээр үндэслэгдэнэ.

ОНХТХХ-ИЙН ЗОРИЛТ

- Оюу Толгой төслийн үйл ажиллагаанд нийгмийн дэмжлэгийг олж авч, хадгалах
- Орон нутаг, төр засаг болон иргэний нийгмийн талуудтай итгэлцэл, нээлттэй байдал, нийтлэг ашиг сонирхол дээр тулгуурласан урт хугацааны найрсаг хамтын ажиллагааг үүсгэн бэхжүүлэх
- Хувь иргэн болон нийгмийн бүлгүүдтэй хамтран орон нутгийн нөөц, хөгжлийн боломжийг нээж үр дүнтэйгээр хамтран ажиллахдаа жендер, нийгэм эдийн засаг, газар зүйн болон соёлын хүчин зүйлсийг харгалзах
- Орон нутгийн харилцааны зорилтуудыг дэмжсэн зорилго, төлөвлөлтийг компанийн түвшинд тодорхойлж, гүйцэтгэлд суурилсан, хэмжигдэхүйц үр дүнд хүрэх
- Оюу Толгой төслийн үйл ажиллагааны нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллүүдийг хянан зохицуулах
- Орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийн оролцоонд тулгуурласан тогтвортой хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх

2. ОНХТХХ-ИЙН ҮНДСЭН ХӨТӨЛБӨРҮҮД

Оюу Толгой төсөл нь 2010 оноос дараах үндсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар үргэлжлүүлэн Өмнөговь аймгийн болон Говийн бүс нутгийн тогтвортой хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц хөрөнгө оруулалтуудыг хийж эхэллээ.

ОРОН НУТАГ, БҮСИЙН ТӨЛӨВЛӨЛТ БА ДЭД БҮТЦИЙН

ХӨТӨЛБӨР (ОНБТДБХ)

Өмнөговь аймаг нь уул уурхайн байгуулалтыг Оюу Толгой болон өөр бусад газруудаар хийсэний үр дүнгээр эдийн засгийн огцом тэнцвэртэй өсөлттэй нүүр тулгарсан билээ. Оюу Толгой болон бусад уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас орон нутгийн шилжилт хөдөлгөөн, Өмнөговь аймгийн суурин газрын хүн ам огцом өсөж, орон нутгийн засаг захиргааны зүгээс үзүүлж буй эрүүл мэнд, нийгмийн хангамж, нийтийн аж ахуйн үйлчилгээ, барилга байгууламжид ихээхэн хэмжээний ачаалал үүсгэж байгаа билээ.

Иймд Оюу Толгой компани нь нийгмийн өмнө хүлээж буй хариуцлагынхаа хүрээнд хүн амын огцом өсөлтөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохицуулах, уурхайн хөрөнгө оруулалтаас тухайн орон нутагт хүртээх үр шимийг нэмэгдүүлэх, улмаар уурхайн үйл ажиллагаанаас үл хамааран тогтвортой орших, эрүүл орчин бүхий суурин газар байгуулах зорилгоор тодорхой төслүүдийг хэрэгжүүлж байна. Үүний нэг нь Бүс, орон нутгийн төлөвлөлт, дэд бүтцийн хөтөлбөр юм.

Хөтөлбөрийн үндсэн зорилго: Төр болон орон нутгийн засаг захиргаа, иргэд оршин суугчидтай хамтран бүс, орон нутгийн хэмжээнд хот байгуулалт, хүн амын суурьшлын бүсийг зохистой төлөвлөн, дэд бүтцийн болон бусад нийгмийн үйлчилгээний хөгжилд хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж, улмаар эдийн засгийн дэвшил авчрахад хөтөлбөрийн зорилго оршино.

Баримтлах зарчим: Уг хөтөлбөр нь бүх талын оролцоонд тулгуурласан төлөвлөлтийн аргачлалыг баримтлан, улмаар орон нутгийг чадавхижуулж, орон нутгийн засаглал, газрын ашиглалтын болон дэд бүтцийн оновчтой төлөвлөлт, менежментийг сайжруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх дэд төслүүд нь орон нутгийн иргэдийн санаачлага оролцоог, төсөл тодорхойлох, боловсруулах, хэрэгжүүлэх, ашиглах бүх үе шатанд байлгахад чиглэнэ.

2010 оны хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд:

- Өмнөговь Аймгийн Бүсийн Хөгжлийн Зөвлөл нь ОТ төслийн гэрээний хэрэгжилтийг ханган дэмжихэд чухал байр суурьтай байгууллага билээ. ОНХТХХ-ээс уг зөвлөлийн ээлжит хурлыг 2010 оны 12 сард зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлж хурлыг амжилттай зохион байгууллаа. Хурлаар зөвлөлийн алсын хараа, зохион байгуулалт, бүтэц,

удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох болон мөн 2010-2011 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлаж гаргасан байна.

- Орон нутгийн дэд бүтцийг сайжруулах хүрээнд: ОТ нөлөөллийн бүсийн хот суурины цахилгаан эрчим хүч болон дулаан үйлдвэрлэх үйлдвэрлэлийн техник эдийн засгийн урьдчилсан үнэлгээг эхлүүлсэн бөгөөд 2011 оны 2-р сард дуусгахаар “Мон-Енержи Консалт” ХХК болон НьюКом ХХК ажиллаж байна. Уг үнэлгээ хийгдсэнээр ОТ болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эдгээр сумдын дулаан хангамж, эрчим хүчээр хангах оновчтой шийдэл, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, нийгэм эдийн засгийн үр өгөөж тооцогдон гарах юм.
- Ханбогд сумын төвийн цэвэр усны хангамжийн эх үүсвэрийн байршлыг тодорхойлох геофизикийн судалгааг Гео Мастер ХХК-аар гүйцэтгүүллээ. Уг судалгаанд үндэслэн усны эх үүсвэрийн нөөцийг тогтоох, өрөмдлөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна. Улмаар хотын усны хангамжийн эх үүсвэрийн байгууламж, нөөцийн резервуар болон дамжуулах хоолойн ажлын зургийг гүйцэтгэх зөвлөх байгууллагатай гэрээг байгуулаад байна.
- Баян-Овоо сумын спорт цогцолборын төвийг шинээр байгуулахаар орон нутгийн захиргаатай тохиролцсоны дагуу Спорт цогцолборын барилгын зураг төслийн ажил иж бүрэн дуусаж, барилга угсралтын ажлыг 2011 ондоо багтааж, инженерийн хангамжийн эх үүсвэрийн хамт шийдвэрлэхээр ажиллаж байна.
- Төслийн шууд нөлөөллийн бүс болох Ханбогд сумын төвийн хот төлөвлөлт, байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, чадавхижуулах ажлыг Монголын хот байгуулалтын хүрээлэнгээс хийж гүйцэтгүүллээ. Уг ажлын хүрээнд Хот байгуулалт, барилга, газар зохион байгуулалтын асуудлыг хариуцаж ажилладаг сумын тамгын газрын ажилтныг ур чадварын хувьд сайжруулахаас гадна, Ханбогд сумын Ерөнхий төлөвлөгөөнд тодотгол оруулж, уг өөрчлөлтийн тухай болон хот төлөвлөлтийн талаар, бусад улс оронд газрын эзэд хэрхэн амьдарч буй хотоо хотын захиргаа, мэргэжлийн байгууллага, хүмүүстэй хамтран хөгжүүлж байгаа, энэ үйл ажиллагааг манай улсад хаана, хэн, хэрхэн амжилттай хэрэгжүүлж байгаа талаар холбогдох мэдээллийг иргэдэд хүргэсэн. Түүнчлэн 2009-2010 оны газар өмчлөлийн үйл ажиллагаанаас хүлээгдэж байсан 400 айлын газар олголтын хэмжилт, мөн 2011 онд олгох 300 айлын газрын хэмжилтийг хийж гүйцэтгэлээ. Уг ажлыг цаашид бие даан хийж гүйцэтгэхэд газар хэмжилтийн Sokkia фирмийн электрон Теодолит, зураг төсөл болон газрын мэдээллийн санг ажиллуулах өндөр хурдны хүчин чадал бүхий компьютер, өнгөт принтер, скайнер, Trimble фирмын GPS, мөн барилгын ажилд хяналт тавихад шаардагдах багаж хэрэгслээр хангалаа.

ОРОН НУТГИЙН БИЗНЕС, ЭДИЙН ЗАСГИЙГ

ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР (ОНБЭЗДХ)

Оюу Толгой Компаний Орон Нутгийн Харилцаа, Тогтвортой Хөгжлийн Хэлтсээс орон нутгийн бизнес, эдийн засгийг дэмжих “ГОВИЙН ШИМ” хөтөлбөрийг боловсруулан, ирэх оны үйл ажиллагааны цар хүрээгээ тодорхойлж, улмаар хамтран ажиллах байгууллагуудаа тодорхойллоо.

Хөтөлбөрийн зорилго: Зах зээлийн зарчимд суурилсан, уул уурхайгаас хараат бус биеэ даасан бизнесийг хөгжүүлэх, өргөжүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах явдал юм.

Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Бизнесийг хөгжүүлэх, орон нутгийн чадамжийг бэхжүүлэх, байгаль орчинд ээлтэй, шинэ арга технологи нэвтрүүлэх, бараа бүтээгдэхүүний хөгжлийг дэмжихийн тулд орон нутгийн бизнес эрхлэгчдэд сургалт, техникийн туслалцаа үзүүлэх, арилжааны банкнаас зээл авахад нь туслах замаар тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэх. Ялангуяа малын түүхий эд болон сүү, цагаан идээ, мах, эсгий, тэмээний ноос, хөөвөр боловсруулах зэрэг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бэхжүүлэхэд түлхүү чиглэнэ.
- Үзэсгэлэн худалдаа, зах зээлийн өдөрлөг, алслагдсан нутгийн үйлдвэрлэгчдийг зах зээлтэй холбоход туслах замаар орон нутаг, бүс, олон улсын хэмжээний үйлдвэрлэгчдийг худалдан авагчтай харилцаа холбоо тогтоох, туршлага солилцоход туслах замаар зах зээлийн харилцааг дэмжиж ажиллана.
- Орон нутгийн бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг сайжруулах, зах зээлийн харилцаа холбоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Төр захиргааны байгууллагатай хамтран хөдөөгийн бизнесийн орчныг сайжруулах, хөдөө аж ахуйн шинэ ололт, нээлтүүдийг нэвтрүүлэхэд хамтран ажиллана.

Хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээ:

„Орон нутгийн бизнес эдийн засгийг дэмжих хөтөлбөр” болон Хангамжийн хэлтэсийн „Орон нутгийн бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжих хөтөлбөр”-тэй хамтран хөдөө орон нутагт бичил болон жижиг дунд бизнес эрхлэгч, малчид иргэдэд зориулан санхүүгийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх үүднээс хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг мөн боловсрууллаа. Энэхүү зээлийн хөтөлбөрийг орон нутаг дахь арилжааны ХААН болон ХАС банкуудтай хамтран хэрэгжүүлэх юм. Эдгээр банкуудын шалгуур үзүүлэлтүүдийг хангасан, эдийн засгийн үндэслэл сайтай, хэрэгжихүйц бизнес төлөвлөгөөтэй, зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэгчдэд 36 сар хүртэлх 1%-ийн хүүтэй зээл олгох боломж нээгдлээ.

Оюу Толгой төслийн нөлөөллийн сумдын алсын харааг тодорхойлох ажил

Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, Өмнөговь аймгийн Судалгаа хөгжлийн сан, Оюу Толгой ХХК хамтран Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс болох Ханбогд, Баян-овоо, Манлай, Даланзадгад сумдын хөгжлийн хэтийн ирээдүйг тодорхойлох зөвлөлгөөнийг энэ оны 10, 11 саруудад зохион байгууллаа.



Баян-Овоо.Зөвлөлгөөний үеэр



Манлай. Зөвлөлгөөнд оролцогчид



Даланзадгад . Зөвлөлгөөний үеэр



Ханбогд. Зөвлөлгөөнд оролцогчид

Энэхүү зөвлөлгөөний зорилго нь уул уурхай, дэд бүтцийн салбар эрчимтэй хөгжиж буй өнөө үед нөлөөллийн бүсийн хөгжлийн хэтийн ирээдүйг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор тодорхойлох, нэгдсэн ойлголтод хүрэх, улмаар ирээдүйн үйл ажиллагааг өөрсдөө төлөвлөхөд оршино. Мөн зөвлөлгөөний үр дүн нь Монгол Улсын Ашигт малтмалын хуулийн 42-р зүйлийг хэрэгжүүлэх суурь болох юм. Энэхүү зөвлөлгөөнд эрүүл мэнд, боловсрол, бизнес, нутгийн захиргаа, малчид, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий 70 орчим иргэд оролцов. Оролцогсод сум орон нутгийнхаа өнгөрснийг цэгнэж, өнөөг ярилцаж, ирээдүйг төсөөлөн сумын хэтийн хөгжлийн үндсэн чиг баримжааг тодорхойллоо.

Зөвлөлгөөнийг олон нийтийн оролцоонд түшиглэн “Ирээдүйн эрэлд” аргачлалаар явуулсан бөгөөд, энэхүү аргачлалыг олон оронд уулзалт зөвлөгөөн

явуулж мэргэшсэн АНУ-ын BSR байгууллагын мэргэжилтнүүд болон манай улсын хөгжлийн асуудлаар мэргэшсэн хүмүүс хамтран удирдлаа.

Дөрвөн сумын оролцогчид маань хөгжлийн гол зорилгууд болох эрчим хүчний хангамж, дэд бүтцийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах зэрэг асуудлуудыг хэлэлцэж тодорхойлсон байна. Эдгээр зорилтууд дээр үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Сумын Хөгжлийн Төлөвлөгөөг боловсруулах юм.

СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨР (СӨХ)

СӨХ нь Оюу Толгой төслийн үйл ажиллагаанаас соёлын өвд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, соёлын өөрчлөлтүүдийг ойлгож, ажиглах, соёлын өвийг таниулах, хадгалах аливаа боломжийг ашиглах, энэ чиглэлээр оролцогч талуудаас гарах санал санаачлагыг хөхүүлэн дэмжих зорилготой.

СӨХ боловсруулах зөвлөх ажил

ОТ төслийн СӨХ боловсруулахаар дотоод гадаадын мэргэжлийн байгууллага, судлаачдын дунд нээлттэй тендер зарлан нийт 13 санал ирснээс Монголын Олон Улсын Өвийн Баг шалгарч гэрээ байгуулан 2010 оны 7-р сараас ажиллаж эхэлсэн. Консорциумын бүрэлдэхүүнд ШУА-ийн Археологийн хүрээлэн, Түүхийн хүрээлэн, Палеонтологийн төвийн судлаачид, АНУ-ын SRI зөвлөх компани, Аризонагийн их сургууль болон Австралийн SEA зөвлөх компаниуд багтах ба биет, биет бус өв, олон нийтийн хөтөлбөр гэсэн багуудад хуваагдан ажиллаж байна.



Малтлагын ажил



Соёлын өвийн хөтөлбөрийг боловсруулах зөвлөх баг



Судалгааны ажилтай Ханбогд сумын захиргааны ажилтнууд танилцаж буй нь

Зөвлөх ажил нийт 12 сарын хугацаатай бөгөөд эхний шатанд ОТ төслийн нөлөөллийн бүсийн Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумд болон

Өмнөговь аймгийн хэмжээнд соёлын өвийн урт хугацааны хөтөлбөр боловсруулахад шаардагдах соёлын биет болон биет бус өвийн суурь судалгаа, хээрийн судалгаа, ном зүй, холбогдох бичиг баримтын судалгаа, эрх зүйн орчны судалгаа, соёлын өвийн бүртгэл, зураглал зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Түүнчлэн хөтөлбөр боловсруулахад орон нутгийн талуудын оролцоог хангах зорилготой уулзалтууд, сум, аймаг, улсын түвшний төр, олон нийт, судалгаа шилжилгээний байгууллагуудын төлөөллийг багтаасан нийт 15 гишүүнтэй Зөвлөх хороог байгуулан ажилдаа орлоо. Төслийн хоёр дахь шатанд соёлын өвийн эрсдэлийн үнэлгээ, орон нутгийн хүлээн зөвшөөрөх соёлын өөрчлөлтийн стандарт тогтоох болон соёлын өвийн хөтөлбөрийг боловсруулж дуусгах юм.

Соёлын өвийн менежментийн тогтолцоог бүрдүүлэх

Рио Тинто компанийн Орон нутгийн харилцааны стандартуудын хүрээнд компанийн дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх Соёлын өвийн менежментийн тогтолцоог ОТ төсөл дээр бүрдүүлэхээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд тус компанийн соёлын өвийн зөвлөх Элизабет Брадшоутай хамтран менежментийн тогтолцооны үндсэн элементүүдийн төслийг боловсрууллаа. Үүнд соёлын өвийн үнэлгээ хийх журам, газар хөндөх явцад соёлын өв дурсгал олдсон тохиодолд авах арга хэмжээний журам зэрэг багтах юм. Төслийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, СӨХ боловсруулах ажлыг гүйцэтгэж буй зөвлөх багийн ажлыг эхлүүлэх зорилгоор Рио Тинтогийн зөвлөх 2010 оны 6-р сард Монголд айлчиллаа. Түүний зөвлөмжийн дагуу төслийн үйл ажиллагаанд өртөж буй нийт талбайд археологийн үнэлгээнээс гадна угсаатны зүйн болон палеонтологийн үнэлгээний нэмэлт ажлыг эхлүүллээ. 2010 оны 7-р сард Палеонтологийн төвийн судлаачид ОТ төслийн онгоцны буудлын талбайд үнэлгээ хийж дүгнэлт гаргасан.

СӨХ-ийн хамтын ажиллагаа

Ханбогд сумын Соёлын төвөөс санаачилсан тус сумын нутаг дээрх байгалийн болон түүх, соёлын дурсгалт газруудыг бүртгэх, баримтжуулах, орчин тойрныг нь цэвэрлэх, тэмдэгжүүлэх зорилготой “Нутгийн гайхамшиг” тойрон аялал төслийг дэмжин 2,363,080 төгрөгөөр санхүүжүүллээ. Аялалын баг Ханбогд сумын нутгаар нийт 2252 км аялал хийсэн. Сумын бүртгэл мэдээллийн санд байгаа 72 газарт очиж 50 гаруй самбар босгон, 20 газарт гортиг татаж, 5 газарт хог цэвэрлэсэн байна. Түүнчлэн аялалын явцад шинээр агуй 9, байгалийн үзэсгэлэнт газар 30 гаруй, булш 31, зэл чулуу 12, бичээс 19, хадны зураг 3, харуулын цамхаг 9, сүм хийд 4, чулуун байгууламж 7 зэргийг илрүүлэн тогтоосон байна. Эдгээрээс 100 гаруйг нь сумын бүртгэл мэдээллийн санд оруулж, 158 газар координат тогтоосон бөгөөд энэ орон нутгийн соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судлаж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж, хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах чухал ажил болсон.

ОРОН НУТГИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ

БАЙДЛЫН ХӨТӨЛБӨР (ОНЭМАААБХ)

Оюу Толгой төслөөс орон нутгийн эрүүл, аюулгүй орчинд тодорхой нөлөөлөл үзүүлэх эрсдэл байгааг ухамсарлан төслийн нөлөөллийн бүсийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал (ЭМАААБ)-д учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх зорилготой хөтөлбөр боловсруулах ажлыг 2010 онд эхлүүлсэн юм.

ОНХТХХ нь “Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал” (ОНЭМАААБ) урт хугацааны хөтөлбөрийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын тендерийг 2009 оны сүүлээр зарлаж, шалгарсан баг Хөх Тэнгэр Хөгжил Консорциум (ХТХК)-тай 2010 оны 6 дугаар сарын 30-нд гэрээ байгуулж хамтран ажиллаж эхэлсэн. Тус консорциум нь 6 түнш байгууллага болон засгийн газар, эрдэм шинжилгээ, судалгаа, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий 30 гаруй түншлэгч байгууллагуудаас бүрдсэн юм.

Зөвлөх үйлчилгээний багийн бүрэлдэхүүнд Монгол улсын Нийгмийн Эрүүл мэндийн хүрээлэн, Эрүүл мэндийн бодлогыг дэмжих сан, Хөгжил судлалын монголын төв, АНУ-д төвтэй Pact Institute, Австралийн JTAI, Германд төвтэй EPOS зэрэг нийгмийн эрүүл мэндийг дэмжих, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах асуудлаар мэргэшсэн, туршлагатай, дэлхийд танигдсан судлаачид багтсан.

Олон талт оролцогч талуудын хамтын ажиллагаа

ОНЭМАААБ хөтөлбөр боловсруулахад төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, ялангуяа орон нутгийн төлөөллөөс бүрдсэн олон талт оролцогчдын хамтын ажиллагаа, оролцоог дэмжсэн зарчимыг баримталсан. Гол оролцогч тал, төслийн нөлөөллийн бүсэд оршин суудаг орон нутгийн иргэдийн оролцоог хангах, дуу хоолойг сонсох зорилгоор дөрвөн сум бүрт Орон нутгийн зөвлөлдөх хороо (ОНЗХ)-г байгуулан ажиллуулсан.

ОНЗХ-г Баян-Овоо сумын Засаг даргын 2010 оны А/85, Даланзадгад сумын Засаг даргын А/154, Манлай сумын Засаг даргын 96, Ханбогд сумын Засаг даргын 126 дугаар захирамжаар доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан юм. Үүнд:

Баян-Овоо сум

Дарга	Э.Бямбахүү	Эмнэлгийн эрхлэгч
Гишүүд	Б.Эрдэнэцэцэг	ЗД-н орлогч
	Ж.Цэдэн	Ахмадын төлөөлөл
	Ц.Энх-Амгалан	Могойт багийн ЗД
	Б.Батбаатар	Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
	Ж.Дэлгэрмаа	Бизнес эрхлэгч

	Д.Баярхүү	Харзаг багийн туслах
Даланзадгад сум		
Дарга	Ч.Баяржаргал	Аймгийн ЭМГ-н дарга
Нарийн бичгийн дарга	Т.Мөнгөнтуул	Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд	Б.Оюунсуртал	ЗД-н орлогч
	Д.Гантуяа	ЗДТГ-н дарга
	Ц.Отгонбат	Цагдаагийн хэлтсийн дарга
	Г.Буянтогтох	ОБ хэлтсийн дарга
	М.Цэндсүрэн	Нийгмийн халамж хариуцсан мэргэжилтэн
	Д.Энхмандах	Аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга
	С.Энэбиш	ТББ-н сүлжээний зохицуулагч
Манлай сум		
Дарга	Г.Рэнцэнноров	Эмнэлгийн эрхлэгч
Гишүүд	Ж.Алтангэрэл	“Буурал Өлзийт” ББН
	Б.Диваажигмид	Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
	У.Нансалмаа	Байгаль хамгаалагч
	Г.Насан-Өлзий	“Өмнөговь Төгс Бадрангуй” ХХК-н захирал
	Д.Отгонбат	Соёлын төвийн эрхлэгч
	Д.Амгалан	БОУУ-н улсын байцаагч
Ханбогд сум		
Дарга	Ж.Наранцэцэг	Эмнэлгийн эрхлэгч
Гишүүд	Д.Хүрэлбаатар	ЗДТГ-н дарга
	Х.Нэхийт	Бизнес эрхлэгч
	Х.Амбаа	Ахмадын хорооны дарга
	А.Улам-Ундрах	Гавилууд багийн ЗД
	Д.Баярбат	Цагдаагийн тасгийн дарга
	Д.Дулмаа	“Номгон Заяа” ТББ-н төлөөлөл
	Тэгшбаяр	Хийдийн тэргүүн

Зөвлөлдөх хорооны гишүүд Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ (ЭМНҮ)-ний хүрээнд судалгаа хийх, ОНЭМАААБ хөтөлбөрийг боловсруулах явцад зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, орон нутгийн иргэдийг идэвхтэй оролцуулахад туслах зэрэг үүрэг хүлээж ажилласан. Ингэхдээ хороод 6 удаа хуралдаж, Ханбогд суманд ажилласан ХТХК-н орон нутгийн салбараас дөрвөн ОНЗХ-ны багийн ахлагчид, гишүүдтэй 5-6 удаа жижиг бүлгээр хуралдах, утсаар зөвлөлдөх зэргээр байнгын харилцаатай хамтран ажиллаж ирсэн. Мөн ОНЗХ-ны гишүүд ХТХК-тай хамтран нөлөөллийн хүрээний сумдад иргэдийн уулзалтыг зохион байгуулж, зарим хурлыг удирдан хөтөлж санаачлагатай ажилласныг дурьдах хэрэгтэй.

ХТХК-ийн судлаач, мэргэжилтнүүд, түншлэгч хамтрагч байгууллагууд бусад холбогдох салбар мэргэжлийн шинжээчид болон ОНЗХ-ны гишүүдийн оролцоо, дэмжлэг тусламж нь олон нийтийн санаа бодлыг тусгасан, өргөн цар хүрээтэй, ЭМНҮ-ий цогц үнэлгээг хийх, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн урт хугацааны хөтөлбөрийг боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан.

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ

ОНЭМАААБ хөтөлбөрийг боловсруулах, цаашилбал уг хөтөлбөрийн үйл ажиллагааг бүс нутгийн болон улсын хэмжээнд бусад оролцогч талуудын түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд уялдуулан зохион байгуулж хэрэгжүүлэх үндэс суурь нь Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ юм.

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ (ЭМНҮ) гэдэг нь шинээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд эрүүл мэндэд учирч болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг урьдчилан таамаглаж, тодруулан судалсны үндсэн дээр цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай цогц арга хэмжээг боловсруулах, хянан зохицуулах системтэй арга хэмжээ юм.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын дунд олон улсын стандартын дагуу анх удаа хийгдсэн ЭМНҮ-ний үр дүн нь зөвхөн нөлөөллийн хүрээний орон нутгийн ард иргэд, Оюу Толгой компанид үр өгөөжөө өгөөд зогсохгүй цаашид манай улсад ажиллаж буй уул уурхайн компаниудад үлгэр жишээ, загвар болох боломжтой юм.

Энэхүү ЭМНҮ нь Олон улсын санхүүгийн корпорацийн (2009) болон Уул уурхай, эрдэс баялгийн олон улсын зөвлөлөөс (2010) боловсруулсан судалгааны аргачлалд үндэслэсэн, ДЭМБ-н зөвлөмжид тулгуурлан, Монголын нөхцөл байдалд зохицуулан хийгдсэн юм. Уг судалгааны аргачлалыг Монгол улсын ЭМЯ-ны АУ-ны Ёс зүйн хяналтын хороо, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.

ЭМНҮ-ний 1 шат: Бичиг баримтын судалгаа, тоон мэдээлэл цуглуулах

Судлаачид Өмнөговь аймгийн ЭМАААБ-тай холбоотой хэвлэлийн тойм, бичиг баримтын судалгаа хийж, төрийн бодлого, холбогдох хууль эрх зүйн актууд болон үйл ажиллагаа, асуудлуудын талаар урьд өмнө хийгдсэн судалгаа, үнэлгээний явцад баримтжаагүй, хөндөгдөөгүй эрсдэл, дутагдалтай байгаа тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн.

Бичиг баримтын судалгаагаар орон нутгийн хүн амын дунд амьдралын хэв маягтай холбоотой цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар, осол гэмтэл давамгайлж байгаа болон архи тамхины хэрэглээ, эрүүл бус хүнс хэрэглэх, зохисгүй хооллолт, хөдөлгөөний дутагдал зэрэг эрсдэлт зан үйл нь хүн амын дундах өвчлөл, нас баралтын гол шалтгаан болж байгаа нь тогтоогдсон.

Энэхүү судалгаагаар АААБ-тай холбоотой халдварт өвчин ба осол гэмтлийн хандлын талаарх мэдээллүүд, мөн дээрх асуудлаар Өмнөговь аймгийг улсын дундажтай харьцуулсан тоо баримтыг тогтоосон. Мөн дутагдаж буй мэдээллийг

тодруулах, орон нутгийн судалгааны баг юуг төвлөрч судлах зэрэг асуудлыг тодорхойлоход чухал ач холбогдолтой болсон.



Мэдээ, баримт цуглуулах үеэр
Ханбогд. 2010.07.29



Аймгийн НЭ-ийн удирдлагатай хийсэн
уулзалт Даланзадгад. 2010 оны 8-р сар

ЭМНҮ-ний 2 шат: Орон нутгийн судалгаа

ЭМНҮ-ний нэг чухал хэсэг болох орон нутгийн судалгааны аргачлалыг боловсруулах, судалгаанд оролцогчдыг сонгох, хамруулах, мэдээлэл цуглуулах, хадгалах, боловсруулах, үр дүнг мэдээлэх явцад Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, аргачлалыг НЭМХ-ийн эрдмийн зөвлөлийн хурал, ЭМЯ-ны дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хороогоор хэлэлцүүлэн баталгаажууллаа.

Орон нутгийн судалгааны аргачлалыг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, Засгийн газар, тухайлбал Улсын Мэргэжлийн Хяналтын Газар, Монгол Улсын Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их сургууль зэрэг байгууллагын нэр хүнд бүхий эрдэмтдээс бүрдсэн Нийгмийн Эрүүл Мэндийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн 2010 оны 9 дүгээр сарын 6-нд хуралдсан хурлаас цаг үеийн хэрэгцээ шаардлага, олон улсын тэргүүн туршлага, стандартад нийцсэн, онол арга зүйн хувьд оновчтой судалгаа гэж дүгнэн санал нэгтэй баталсан юм.

ЭМНҮ нь Монгол Улсын хувьд шинэ судалгаа тул эрдэмтэд 2 цагийн турш асуудал дэвшүүлсэн сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Үүнд: төсөл эхлэхээс өмнө болон төсөл дууссаны дараа иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг хэрхэн илрүүлэн тогтоох, нөлөөллийн хүрээ, хэмжээг яаж үнэлэх, энэхүү судалгаа нь эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний өргөн хүрээтэй үйл явцын чухам аль хэсэгт хамаарах талаар нухацтай ярилцсан юм. Ингээд судалгаа нь ЭМНҮ болон Оюу Толгой төслийн нөлөөллийн хүрээний ОНЭМАААБ хөтөлбөрийг боловсруулахад чухал шаардлага, ач холбогдолтойн зэрэгцээ үндэсний хэмжээнд түгээн хэрэглэх боломжтойг цохон тэмдэглэлээ..

Мөн орон нутгийн судалгаа явуулах судлаачдад зориулсан арга зүйн сургалт болон Төв аймгийн Эрдэнэ суманд хийсэн туршилт судалгаа нь судлаачдад цаашид аргачлалаа улам сайжруулах боломж олгосон юм.

Энэхүү судалгааны аргачлалыг боловсруулахад ХТХК-ын хамтрагчид, нэр хүндтэй судлаачид болох Др Одноо Браун (Пакт Институт), Др Жанет Хонен, Др Жейн Томасон (Жэй Ти Эй Интернейшнл), Б.Баясгалан, Ц.Эрдэнэчимэг (ХСМТ), Др.Силке Грэзер (ЕРОS), Др О.Чимэдсүрэн (ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль), Др Ц.Содномпил (Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Эрүүл Мэндийн Газар), Др Д. Энхбат (Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам), Др Х.Алтайсайхан (Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль), Др Б. Отгонжаргал, Др З.Мэндсайхан (Эрүүл Мэндийн Яам), Др Ж.Оюунбилэг, Др Н.Сайжаа, Др П.Энхтуяа, Др Ж.Купул (Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн) нар үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Судалгаа явуулах журмын дагуу Эрдмийн зөвлөлийн хурлаас баталсан судалгааны аргачлалыг, бусад шаардлагатай материалын хамт Эрүүл мэндийн яамны Ёс зүйн хяналтын хороонд оруулан хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо 2010 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн хурлаараа Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний хүрээнд хийгдэх орон нутгийн судалгааны аргачлалыг хэлэлцэн, ёс зүйн хяналтын хорооны дүрмийн дагуу явуулсан нууц санал хураалтаар тус хорооны гишүүдийн 77 хувийн саналаар батлав.

Хорооны гишүүд судалгааны талаар өндөр сэтгэгдэлтэй байсан бөгөөд уул уурхайн үйл ажиллагаа нөлөөллийн хүрээний орон нутгийн хүн амын эрүүл мэндэд үзүүлэх, уурхайн сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Оюу Толгой ХХК санаачлага гарган судалгаа хийж байгаа нь ёс зүйн хувьд хариуцлагатай алхам гэдгийг цохон тэмдэглэсэн юм.

Орон нутгийн судалгааны тоон мэдээлэл цуглуулах ажил 2010 оны 10 сарын 10–24-ний өдрүүдэд хийгдсэн. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Эрүүл мэндийн бодлогыг дэмжих сан, Монголын хөгжил судлалын төвийн мэргэжилтнүүдээс бүрдсэн баг Оюу Толгой төслийн нөлөөллийн хүрээний Даланзадгад, Баян-Овоо, Ханбогд, Манлай сумдаар ажиллав. Орон нутгийн судалгааг бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага, эрүүл мэндийн нөөцийн үнэлгээ гэсэн тоон болон чанарын судалгааны аргуудыг ашиглан явуулсан.

Судалгаа эхлэхийн өмнө иргэдийн уулзалтуудыг зохион байгуулан хийгдэх ажлын талаар мэдээлэл түгээсний дараа бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага, эрүүл мэндийн нөөцийн үнэлгээг хийх ажлуудаа эхлүүлж байсан. Сум бүрт нэг баг дээр малчдын бүлгийн ярилцлага зохион байгуулсан нь судлаачдад малчидтай чөлөөтэй ярилцаж, тэдний санал бодлыг сонсож судлах боломжийг

олгов. Орон нутгийн зөвлөлдөх хорооны гишүүд судалгааг зохион байгуулах бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлж ажилласан.



Иргэдийн уулзалтын үеэр
Даланзадгад. 2010 .10.11



Эрүүл мэндийн нөөцийн үнэлгээний үеэр
Даланзадгад. 2010.11.12



Малчдын бүлгийн ярилцлагын дараа
Баян Овоо. Могойт баг. 2010.10.16



Сумын иргэдийн уулзалт
Манлай. 2010.10.21

ЭМНУ-ний 3 шат: Эрсдлийн шинжилгээ

ЭМНУ-ний өөр нэгэн чухал хэсэг болох Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын эрсдлийн шинжилгээг хэлэлцэх мэргэжлийн шинжээчдийн зөвлөлдөх уулзалтыг 10 дугаар сарын 28-ны өдөр Нүхт цолцолборт зохион байгуулсан бөгөөд уг уулзалтанд холбогдох салбаруудын нийт 21 шинжээч оролцсон юм. Шинжээчдийн зөвлөлдөх уулзалт нь төслийн шууд болон шууд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга замыг шинжээчдийн оролцоотойгоор шинжлэх, эрэмбэлэн үнэлэх зорилготой ажилласан. Шинжээчдийг ажилладаг байгууллагын харьяаллыг харгалзан үзэхээс илүүтэй тухайн мэргэжилтний мэдлэг, туршлагад нь тулгуурлан сонгосон бөгөөд тэд жижиг ажлын хэсэг, бүлгүүдэд хуваагдан ажилласан юм. Хэлэлцүүлгийн үеэр байгаль орчин, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, ёс зүй, аюулгүй байдлын салбарын

туршлагатай, нэр хүндтэй шинжээчид тохиолдож болзошгүй олон талт, өргөн хүрээтэй эрсдэл, нөлөөллийн талаар тодорхой бөгөөд нэгдсэн саналуудыг дэвшүүлэв.

ЭМНҮ-ний олон улсын аргачлалын дагуу, шинжээчид болзошгүй эрсдэл тус бүртэй холбогдон үүсэх нөлөөлөл, өртөмхий хүн амын бүлгүүдийг хэлэлцэж, цар хүрээ, тохиолдох магадлалыг үнэлж, ач холбогдлоор нь эрэмбэлэн үнэлж, шинжилсэн юм. Шинжээчдийн зөвлөлдөх уулзалтын эрсдлийн үнэлгээний үр дүнг бусад тоо мэдээлэл, тухайлбал орон нутгийн судалгааны үр дүн, орон нутгийн зөвлөлдөх хороо, түншүүдийн уулзалтын үр дүн, санал зөвлөмжтэй нэгтгэн ЭМНҮ-ний эцсийн тайлан болон ОНЭМАААБ-ын хөтөлбөрийг боловсруулахад ашигласан юм.

ЭМНҮ-ний 4 шат: Эрсдэл бууруулах үйл ажиллагаа, арга хэмжээг эрэмбэлэх, дүн шинжилгээ хийх

ЭМНҮ-ий эрсдлийн шинжилгээ хийх, ОНЭМАААБ-н хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй явуулж, тулгамдаж буй асуудлууд, тэдгээрээс тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлуудыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэсэн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Үүнд:

Орон нутгийн оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт

Даланзадгад хотод 2010 оны 11 сарын 22-ны өдөр болсон Зөвлөлдөх уулзалтанд Оюу Толгой төслийн нөлөөллийн хүрээний сумдын Орон нутгийн зөвлөлдөх хорооны гишүүд, зарим холбогдох байгууллагуудын төлөөлөл бүхий нийт хорин хоёр хүн оролцсон. Оролцогчид нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнууд, цагдаагийн байгууллага, ТББ-ын тэргүүн, орон нутгийн засаг захиргааны ажилтнууд зэрэг олон салбарын төлөөлөл байлаа.

Уг уулзалтын үеэр Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын нөлөөллийн үнэлгээний үр дүн болон Оюу Толгой уурхайн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй эрсдлийн үнэлгээнд тодорхой саналуудыг өгч, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа, арга хэмжээний дэлгэрэнгүй жагсаалтыг хэлэлцэн зөвлөж, үйл ажиллагааг ач холбогдлоор нь эрэмбэлсэн юм. Зөвлөлдөх уулзалтын үеэр, оролцогчид хот хөдөөгийн хооронд болон сум тус бүрийн хувьд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын тулгамдсан асуудал, хэрэгцээ шаардлага ялгаатай болохыг дурдаж, зарим арга хэмжээг нэгтгэх нь чухлыг санал болгов. Мөн сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа, арга хэмжээ, тэдгээрийн гарах үр дүн, хэрэгжих боломж, сум тус бүрийн онцлог зэргийг харгалзан эрэмбэлж, өөрсдийн санал бодлыг ХТХК-н судлаачидтай хуваалцлаа. Тэд аймаг, сум, багийн түвшинд орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд хариуцлагатай

хандах, боловсролын болон эрүүл мэндийг дэмжих компани ажлыг байнга өрнүүлж олон нийтийн оролцоог хангахыг санал болгосон юм.

ХТХК-ийн түнш байгууллагуудын зөвлөлдөх уулзалт

ХТХК-ын түншүүдийг оролцуулсан Зөвлөлдөх уулзалтыг 2010 оны 11 сарын 25-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, ХТХК-ын түнш холбогдох яамд, агентлагийн албан хаагчид, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцож, ЭМНҮ-ний үр дүнг хэлэлцэж тодорхой сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны талаар хэлэлцэж санал солилцов. Тэд хөтөлбөрт тусгагдах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд хамгийн чухал ач холбогдолтой хүчин зүйлсийг хэлэлцэж, ОНЭМАААБ-ын хөтөлбөрийг Засгийн газар, үндэсний болон орон нутгийн бодлого, хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулах, засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, бусад уул уурхайн компанийн үйл ажиллагаа, олон салбарын үйл ажиллагаанаас хамааралтай гэр бүлийн сайн сайхны асуудал, шилжин суурьшигч хөдөлгөөнт хүн амын бүртгэл, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын асуудлаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо чухал болохыг дурьдав. Тэд Оюу Толгой ХХК урт хугацааны эрсдэл, нөлөөллийг сааруулахдаа Засгийн газрыг аль болох татан оролцуулах, хамтарч ажиллахыг санал болгосон юм.

Эрүүл мэндийн салбарт уул уурхай Төр Хувийн Хэвшлийн Түншлэл (ТХХТ)-ийг хөгжүүлэх талаар зохион байгуулсан зөвлөлдөх уулзалт

ЭМНҮ-ний үр дүн Өмнөговийн нутаг дэвсгэрт Оюу Толгой төслөөс гадна бусад олон компани, засаг захиргааны болон аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг учраас тухайн орон нутагт хуримтлагдсан нөлөөлөл үүссэн, төрөөс үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний чанар, нөөц хангалтгүй зэрэг тулгамдсан асуудлууд байгаа гэж харуулсан. Тиймээс ОНЭМАААБ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын идэвхитэй оролцоо, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй олон талт оролцогч нарын хамтын ажиллагааг бий болгох Засгийн газрын тэргүүлэл нэн чухал байна. Эрүүл мэндийн салбарт Төр хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийг хөгжүүлэх талаар Зөвлөлдөх уулзалтыг 2010 оны 12 сарын 7-ны өдөр Их тэнгэр цогцолборт зохион байгуулсан. Уг уулзалтанд Эрүүл мэндийн яам, түүний харьяа газар агентлагууд, Улсын мэргэжлийн хяналтын газар, Төрийн өмчийн хороо, Сангийн яам, ТББ-ын төлөөллүүд болон Оюу Толгой ХХК-н ОНХТХХ-н ажилтнууд оролцов.

Зөвлөлдөх уулзалтаар Эрүүл мэндийн салбарт уул уурхайн чиглэлийн ТХХТ-ийг хөгжүүлэх асуудлыг Оюу Толгойн жишээн дээр тулгуурлаж ТХХТ-ийг хөгжүүлэх суурь ойлголт, тодорхойлолтуудыг танилцуулах; энэ чиглэлд хэрэгжсэн олон улсын сайн жишээ, сургамжтай асуудлуудыг танилцуулах; Оюу Толгойн жишээн дээр Орон нутгийн ЭМАААБ-ын хөтөлбөрийн загвар боловсруулах хэрэгцээ шаардлага,

аргачлалыг хэлэлцэх; ЭМЯ-ны хүрээнд уул уурхайн компаниудтай ТХХТ-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээ, үндсэн чиглэлүүдийг хэлэлцэх зэрэг асуудлыг авч хэлэлцлээ.

Уулзалтыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа нээж, ХТХК-н зөвлөх Жейн Томасон уулзалтын зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүнгийн талаар танилцуулснаар уулзалт эхэлж хэд хэдэн сэдвээр илтгэлүүд тавигдлаа. Тухайлбал, “Эрүүл мэндийн салбарт ТХХТ-ийг хөгжүүлэхэд баримталж буй ЭМЯ-ны бодлого чиглэл” илтгэлийг ЭМЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга С.Энхболд, “Оюу Толгой төслийн Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ, орон нутгийн ЭМАААБ-ын хөтөлбөрийг боловсруулах ажлын явцын мэдээлэл” илтгэлийг ХТХК-н зөвлөх Л. Энхтүвшин, “Эрүүл мэндийн салбарт уул уурхайн компаниудтай хамтран хэрэгжүүлэх ТХХТ-ийн олон улсын тэргүүн туршлага” болон “Монгол улсад нэвтрүүлж болохуйц ТХХТ-ийн хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам” илтгэлүүдийг ХТХК-н зөвлөхүүд тус тус тавьж үдээс хойшхи хуралдаанд Эрүүл мэндийн салбарт уул уурхайн компаниудтай хамтран хэрэгжүүлэх ТХХТ-ийн хүрээ, тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх арга замуудыг бүлгээр хэлэлцэж ажиллав.

Зөвлөлдөх уулзалтаас гарсан зөвлөмжүүдээс:


- Монгол Улсын Засгийн Газраас эрүүл мэндийн асуудлаар ТХХТ-ийг уул уурхайн бүс нутгуудад хэрэгжүүлэх чиглэлээр стратегийн бодлого, хөтөлбөр яаралтай боловсруулж хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор урган гарч байна. Түншлэлийн энэхүү бодлого нь уул уурхайн бүс нутгуудын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тодорхой асуудлуудыг хамарна.
- Уулзалтын үеэр танилцуулсан олон улсын туршлагаас харахад ТХХТ-ийн хүрээг боловсруулах, хэрэгжүүлэх нь нилээн нарийн түвэгтэй асуудал юм. Үүнд оролцогч талуудыг нарийвчлан тодорхойлох, тал бүрийн хүлээх үүрэг хариуцлагыг томъёолох, мөн түншлэгч талуудын оролцооны хүрээнд ямар арга хэмжээг санхүүжилтийн ямар эх үүсвэрээр хангахыг нэг бүрчлэн тодорхойлох хэрэгтэй.
- ТХХТ-ийг хэрэгжүүлэхэд тухайн бүс нутгуудад амьдарч буй орон нутгийн иргэдийн дуу хоолойг сонсч тэдгээрийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээс ажлын амжилт шалтгаална.
- Уулзалтанд оролцогчид ТХХТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлуудыг хэрхэн санхүүжүүлэх талаар ярилцаж эрүүл мэндийн даатгалын санхүүжилт болон уул уурхайн компаниудын төлж буй рояалти татварын тодорхой хэсгийг тухайн бүс нутгийн хүн амын эрүүл мэндийг дэмжих, эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлийн арга хэмжээнд дайчлах чиглэлээр хууль эрх зүйн орчин, бодлогын арга хэмжээг боловсруулж төлөвлөх шаардлага байгааг онцлон тэмдэглэлээ.

- Уулзалтанд оролцогчид хандивлагч байгууллагуудын үйл ажиллагаа, эрүүл мэндийн салбарт ажилладаг тусламжийн сангуудын хөрөнгийг энэхүү чиглэлд хандуулах нь зүйтэй гэж үзлээ.
- ТХХТ-ийн арга хэмжээг бүс нутгийн эрүүл мэндийн нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж зөвхөн нэг уурхай бус хэд хэдэн уурхайн түншлэлийн түвшинд хэрэгжүүлэх нь зүйтэй байгааг ярилцав.
- ТХХТ-ийн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхэд хяналт үнэлгээний ажлыг хэрхэн гүйцэтгэхээс ажлын амжилтын ихээхэн хэсэг нь шалтгаалах тухай мөн цохон тэмдэглэв.

2011 онд хийгдэх ажлууд:

- ОНЭМАААБ хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, дагалдах бичиг баримтуудыг эргэн хянаж, эцэслэн боловсруулах;
- ОНЭМАААБ хөтөлбөрийг боловсруулах төслийн үр дүнг орон нутагт танилцуулах уулзалтыг зохион байгуулах;
- Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тайланг хянаж олон нийтэд түгээх; ЭМНҮ-ний эрсдлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, ОНЭМАААБ-н хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, уялдааг хангах үйл явцыг ЭМЯ болон бусад холбогдох яам, хэрэгжүүлэгч агентлагууд, олон улсын төслүүдтэй зөвлөлдөх.

Хөтөлбөрийг боловсруулах үйл ажиллагааны бүдүүвч:



ОРОН НУТГИЙН ОРОЛЦООТОЙ БАЙГАЛЬ ОРЧИН МОНИТОРИНГИЙН ХӨТӨЛБӨР (ОНОБОМХ)

Нутгийн ургамлын үр цуглуулах санаачлага

Оюу Толгой ХХК-ын Байгаль орчны хэлтсээс 2010 онд төслийн үйл ажиллагаагаар хөндөгдсөн газруудад биологийн нөхөн сэргээлт хийхэд нутгийн ургамлын үрийг ашиглах санаачлага гаргасан. Бид энэхүү санаачлагыг дэмжин Байгаль орчны хэлтсийн мэргэжилтнүүдийн зөвлөмж, сумдын ажилтнуудынхаа дэмжлэгээр Манлай, Ханбогд сумын нутгаас баглуур, бор бударгана, бүйлс, шар модон хотир зэрэг 12 төрлийн ургамлын үрийг 2010 оны 9-11-р сарын хооронд орон нутгийн иргэдийн хүч, оролцоотойгоор түүж цуглуулах ажлыг амжилттай зохион байгууллаа. Энэ нь ОТ төслийн байгаль орчны үйл ажиллагаануудад орон нутгийн иргэд, малчдыг оролцуулсан анхны ажил болсон юм. Эхний удаад нийт 137.5 сая төгрөгийн өртөг бүхий 10.3 тонн нутгийн ургамлын үр цуглуулж Байгаль орчны хэлтсийн биологийн нөхөн сэргээлтэд зориулсан үрийн фондод хүлээлгэн өглөө.



Манай ажилчид үр хүлээж авч буй нь



Манлай.



Ханбогд.

Ургамлын үр түүх гарын авлага



Орон нутгийн иргэдийн оролцоотойгоор Нутгийн ургамлын үр цуглуулах санаачлагын хүрээнд говийн ургамлын онцлог болон түүний үрийг хэрхэн зөв түүх арга, аргачиллын тухай заавар зөвлөмжийг Байгаль орчны хэлтсийн ургамал судлаач Ж.Санжид, ОНХТХ хэлтсийн хөтөлбөрийн ажилтан Н.Мөнхбаяр нар боловсруулсан юм. Бид энэхүү гарын авлагыг нийт 1000 хувь хэвлүүлж орон нутгийн иргэдэд зориулсан сургалтанд ашиглахаар төлөвлөж байна.

Биологийн нөхөн сэргээлтэд орон нутгийн иргэдийн оролцоо

Оюу Толгой төслийн байнгын онгоцны буудал баригдах хүртэл хугацаанд түр ашиглах “Оюут” орон нутгийн онгоцны буудлыг 2010 оны 9-р сард ашиглалтанд оруулсан бөгөөд уг онгоцны буудлын барилгын ажлын явцад 77 га орчим газрын хөрсийг хөндсөн. Тиймээс хууль журмын дагуу ОТ төслийн Байгаль орчны хэлтэс, ОНХТХ хэлтэс хамтран нийт 65 га талбайд 975 кг нутгийн ургамлын үр цацаж биологийн нөхөн сэргээлт хийсэн. Цацсан үрийг бог малын хөлөөр гишгүүлж нягтруулсан.

Энэ ажилд онгоцны буудлын ойр орчимд амьдардаг 12 малчин өөрсдийн санаачлагаар хамтран оролцсон нь цаашид төслөөс хэрэгжүүлэх байгаль орчны нөхөн сэргээлтийн ажилд орон нутгийн иргэдийн оролцоог хангах эхлэл боллоо./зураг

Бэлчээрийн менежмент

Өмнөговь аймгийн Ханбогд сумын бэлчээр нутаг нь Оюу Толгой төсөл болон бусад уул уурхай, түүний дэд бүтцийн нөлөөлөлд тодорхой хэмжээгээр өртөж байгаа учраас Оюу Толгой төслөөс сумын бэлчээрийн менежментийг сайжруулах төслийг санаачлан санхүүжүүлж байна. Уг төслийн хэрэгжүүлэгч байгууллага нь Монголын Бэлчээрийн Менежментийн холбоо бөгөөд тус байгууллага нь өнгөрсөн 5 жилийн хугацаанд нийт 55 суманд Бэлчээрийн менежментийг хөгжүүлэх чиглэлээр ажилласан туршлагатай бөгөөд одоогоор бэлчээрийн тухай хуулийг санаачлан УИХ-д өргөн бариад байна.

Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо нь Ханбогд сумын онцлог, нутгийн иргэдийн амьжиргаа, нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор 2010 оны 9 сард Ханбогд суманд ажилласан бөгөөд Оюу Толгой ХХК хамтран ажиллах гэрээг 2010 оны 10 сард байгуулсан. Уг төслийн хүрээнд Ханбогд суманд бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх, цаашид тогтвортой үргэлжлүүлэх зорилгоор “Ханбогд



МБМХ-ны мэргэжилтнүүдтэй ярилцаж буй

...



Ханбогд. Малчид

Алтан Нутаг” ТББ байгуулагдаж, тэргүүнээр Т.Түвшинболд сонгогдон ажиллаж байна. ТББ-ын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Жавхлант багийн засаг дарга Н.Ширнэн, Гавилууд багийн малчин Х.Бадамсэрээжид, Хадгаламж банкны эрхлэгч Т.Буян-Өлзий, “Хан дизель” улсын үйлдвэрийн газрын дарга Ц.Идэрзориг нар ажиллаж байна.

2010 оны байдлаар Ханбогд сумын төвд малчдад зориулсан “Бэлчээрийн менежмент”-ийг таниулах сургалтыг зохион байгуулж, Гавилууд багийн нутагт бэлчээр ашиглагчдын гурван хэсэг байгуулагдаад байна. БАХ-ийн зохион байгуулалтад орсноор малчид бэлчээрээ хуваарилан ашиглаж, хамтарч хоршин амьжиргаагаа дээшлүүлэх санаачлага гарган хэрэгжүүлэх боломжтой болох юм. Жишээ нь: бэлчээр хөцөөлөх (хашаалах), малын тэжээлийн ургамал тариалах ажлыг турших, тариалах, малын хороогоо сайжруулан тохижуулах, худаг ус гаргах, засах, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, ахиу үнээр борлуулах гэх мэт.

Төслийн хүрээнд БАХ-ийн мөнгөн хуримтлал буюу дундын сан байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд Оюу Толгой төслөөс малчдын дундын сангийн анхны хөрөнгө оруулалтын 50 хувийг санхүүжүүлэх юм.

Бэлчээрийн зураглал

Оюу Толгой ХХК нь төслийн дэд бүтцийн нөлөөлөлд өртөж буй айл өрхүүдийг тодорхойлох, цаашлаад тэдэнд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр хийх ажлаа төлөвлөх зорилгоор малчдын бэлчээрийн зураглалын судалгааг тэдний өөрсдийнх нь оролцоонд тулгуурлан хийдэг юм. Энэхүү ажлын хүрээнд 2010 онд ОТ-Гашуун Сухайтын замын дагуух малчдын судалгааг дуусгаж, Гүний хоолойн дагуух малчдын бэлчээрийн зураглалыг хийж эхэллээ.

3. БУСАД ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Эмчийн тэтгэлэгт хөтөлбөр

Эмчийн тэтгэлэгт хөтөлбөр нь Говийн бүсийн алслагдсан сумдыг эмч, эмнэлгийн ажилтнаар ханган орон нутгийн иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх, эрүүл мэндийн чанартай, найдвартай үйлчилгээг хүргэх боломжийг хангах зорилготой. Энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийг 5 жилийн хугацаатай 2005-2010 оны хооронд амжилттай хэрэгжүүлсэн. Эмчийн тэтгэлэгт хөтөлбөрийн шаардлага хэрэгцээг нь үндэслэн 6 дахь жилдээ сунган 2011 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болсон билээ. Энэ хугацаанд нийт 25 эмч хөтөлбөрт хамрагдсан бөгөөд одоогийн байдлаар Өмнөговь аймгийн Даланзадгад, Гурвантэс, Баяндалай, Булган, Номгон, Ноён, Сэврэй, Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо, Цогтцэций сумдад 15 эмч ажиллаж байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд компани Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн газрын даргаар ахлуулсан Удирдлагын багтай хамтран ажиллаж байна. 2010 онд нийт 11,570,000.00 төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн эмч, эмнэлгийн чадавхи, чанарыг дээшлүүлэхэд хийгээд байна.



Эмчийн орон сууц хөтөлбөр

Оюу Толгой ХХК 2006 оноос эхлэн орон нутгийн эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр Эмчийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2007 онд Ханбогд, Ноён, Манлай, Булган, Баян-Овоо сумдад, 2008 онд Цогтцэций, Мандал-Овоо, Баяндалай, Сэврэй, Гурвантэс, Номгон сумдад эмчийн орон сууц баригдаж ашиглалтанд орлоо. Компани орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор уг 11 суманд орон сууцыг орон нутгийн барилгын компаниудаар бариулах бодлого баримталсан бөгөөд Говь Гурван Сайхан компани 3, Гал Мөнх компани 2, Оршдос компани 2, Дэт компани 1, Даян Байгаль компани 3 сумдын барилгын гүйцэтгэгчээр тус тус ажилласан байна.

2009 болон 2010 онд Хүрмэн, Цогт-Овоо сумдад нэг бүр нь 47,250,000.00 төгрөгийн (нийт 94,500,000.00 төгрөг) өртөг бүхий эмчийн орон сууцнуудыг барьж дуусгасан.

Оюутны тэтгэлэгт хөтөлбөр

Оюу Толгой ХХК нь 2005–2010 оны хооронд 5 жилийн хугацаатай Оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд Өмнөговь аймгийн 133 оюутан энэхүү тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж, 46 төгсөгч маань төрөлх нутагтаа ажиллаж амьдарч байна. 2010–2011 оны хичээлийн жилд 1 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн сунгаж, ЕБСургуулийн 11-р ангийг төгсөн их, дээд сургуульд элсэн суралцах гэж буй сурагчид болон Монголын дотоодын их, дээд сургуулийн 2–5-р курст дэвшин суралцах оюутан сурагчдын дунд тэтгэлэгт хөтөлбөрөө зарлан, сонгон шалгаруулж хэрэгжүүлэхээр болсон.

Тэтгэлэгт хөтөлбөрийн зарлал, мэдээллийг 2010 оны 08 дугаар сарын 12–18-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн бүх сумдад зарлаж, Даланзадгад сумаас 81, бусад сумдаас 50, нийт 131 оюутан, сурагчдын материалыг хүлээн авч 2010 оны 8 дугаар сарын 19–20 ны өдрүүдэд бичиг баримтын бүрдэл, эссэ, ярилцлага гэсэн 3 үе шаттайгаар сонгон шалгаруулалтыг хийлээ.

Сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, шударга явуулах үүднээс Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол соёлын газар, иргэний нийгмийн байгууллага, Оюу толгой ХХК-ий төлөөллөөс бүрдсэн шүүгчдийн бүрэлдэхүүн ажиллаа. Онооны дарааллаар байр эзлүүлж эхний 30 оюутныг сонгон шалгаруулалтанд тэнцсэнд тооцож, оюутны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдуулахаар болсон.

Хөтөлбөрт хамрагдаж байгаа 30 оюутны дотор Даланзадгад сумаас-21, Ханбогд сумаас-3, Цогтцэций, Цогт-Овоо, Ханхонгор, Ноён, Сэврэй, Гурвантэс сумдаас тус бүр 1 оюутан шалгарсан байна. Оюутны тэтгэлэгт хөтөлбөрт зөвхөн Монголын дотоодын их, дээд сургуульд суралцдаг оюутнууд хамрагдсан бөгөөд сургалтын төлбөр болон дотуур байрны зардлыг Оюу Толгой ХХК 100% санхүүжүүлсэн билээ. 2010 онд нийт 72,332,204.46 төгрөгийг Монголын ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэх үйлсэд зарцуулаад байна.

4. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН АРГА ХЭМЖЭЭ

Байгаль орчны мэдээллийн хүртээмжийн үнэлгээний судалгаа

Орон нутгийн иргэдээс хүрээлэн байгаа байгаль орчин, тухайлбал агаар, ус, ан амьтан, тусгай хамгаалалттай газар, замын тоос, дэд бүтцийн

талаар санал бодлыг нь сонсохоор 3 болон 4-р сард байгаль орчны мэдээллийн үнэлгээний судалгаа хийлээ. Энэхүү хоёр сар үргэлжилсэн судалгааны үеэр орон нутгийнхан одоогийн байгаа байдалд үнэлэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлсэн юм.

Орон нутгийн зөвлөлдөх бүлэг байгууллаа

Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс болох Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад сумдын орон нутгийн иргэд, байгууллагууд болон ОНХТХ хэлтсийн хоорондын харилцааны анхдагч нэгж болох, түүнчлэн хэлтсийн хөтөлбөр, төслүүд, орон нутгийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэх үүрэг бүхий “Орон нутгийн зөвлөлдөх бүлэг”(ОНЗБ)-ийг дээрх сумдад байгуулах санаачлагыг Оюу Толгой ХХК-ны ОНХТХХ дэмжин ажиллаж орон нутгийн иргэд, удирдлага, иргэний нийгмийн төлөөлөл зэрэг оролцогч бүхий л талуудын оролцоог хангасан төлөөллийг сонгож ОНЗБ-ийг байгууллаа.

Даланзадгад сумын ногоочдод зориулсан сургалт, судалгаа

Оюу Толгой ХХК-ий Хангамжийн хэлтэс нь “Canadian Energy Consultancy” компанитай хамтран Даланзадгад сумын хүнсний ногоо тариалагч иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг чадваржуулах, цаашид Оюу Толгой ХХК-д ногоо нийлүүлэх боломжийг судлах зорилгоор Өмнөговь аймагт 2010 оны 5 дугаар сарын 31-нээс 2010 оны 6 дугаар сарын 3-ны өдрүүдэд сургалт болон судалгааны ажлыг зохион байгууллаа.



Даланзадгад. Сургалтын үеэр

Уг ажлын хүрээнд Даланзадгад сумын 100 гаруй ногоочин өрх тус мэргэжлийн байгууллагын гишүүдтэй биечлэн уулзахын зэрэгцээ тариалангийн талбайдаа урьж, одоогийн чадавхи, нөхцөлөө танилцуулсан.

Тариаланчид маань өөрсдийн давуу болон сул талаа тодорхойлон, бизнес төлөвлөгөө боловсруулах заавар зөвлөгөө авч, ирээдүйд Оюу Толгой ХХК-д ногоо нийлүүлэхийн тулд ямар технологи, арга зүйгээр ногоо тарих талаар мэргэжлийн сургалтанд хамрагдлаа.

“Уул уурхайн компани, нутгийн иргэд, орон нутагтай харилцах харилцааг бэхжүүлэх нь” сургалт зохион байгууллаа

Оюу Толгой ХХК нь орон нутгийн иргэдийн оролцоо болон орон нутагтай харилцах харилцааг чухалчлан анхаардаг билээ. Энэхүү ажлынхаа хүрээнд Австрали улсын Квийнслэндын Их Сургуулийн багш нарыг урьж, 2010 оны 08-р сарын 23-25-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо гурван өдрийн эрчимжүүлсэн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд Оюу Толгой ХХК өөрийн ажилтнууд болон орон нутгийн төрийн бус байгууллагын гишүүдийг хамрууллаа. **Орон нутгийн гомдол саналыг зохицуулах**



Сургалтанд оролцогчид

OASIS системээр дамжуулан иргэдээс ирсэн гомдол саналыг цаг тухайд нь зохицуулан ОНХТХХ-ийн ажилчидтай хуваалцаж байна. Орон нутгаас ирсэн гомдол, хурлын протокол, болон хандив туслаж хүссэн хүсэлтийг OASIS-д оруулдагаас гадна, авах арга хэмжээнүүдийг тусгасан байгаа.

Энэхүү \$45,600-ийг өртөг бүхий ашиглалтын системийг Borealis компанитай хэлэлцэн 2010 оны 9 дүгээр сарын 01-ээс 1 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж эхлээд байна.

Орон нутгийн ажил эрхлэлтийг дэмжих

2010 оны эцсийн байдлаар 4065 Монгол иргэн Оюу Толгой ХХК болон гэрээт компаниудад ажиллаж байна. Үүнээс гадна хэлтсүүд олон улсын болон үндэсний, орон нутгийн зөвлөх, мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллаж байна. Тухайлбал, ОНЭМАААБХ, СӨХ болон ОНБТДБХ болон Эдийн засгийн Нөлөөллийн Үнэлгээ дээр 80 гаруй дотоодын зөвлөх багуудтай гэрээгээр ажиллаж байггаа юм.

Хүснэгт 1. Ажилд орсон хүмүүсийн тоо, оршин суух газрын үүслээр нь

Хүйс	Ханбогд	Баян Овоо	Манлай	Даланзадгад	Өмнө Говь	Монголын бусад хэсгээс	Нийт
ОТ ХХК							
Эрэгтэй	23	5	7	64	14	237	350

Эмэгтэй	11	1	5	18	2	212	249
Нийт	34	6	12	82	16	449	599
Бусад							
Эрэгтэй	260	14	28	163	4	2200	2669
Эмэгтэй	335	12	26	77		347	797
Нийт	595	26	54	240	4	2547	3466
Нийт							
Эрэгтэй	283	19	35	227	18	2437	3019
Эмэгтэй	346	13	31	95	2	559	1046
Нийт	629	32	66	322	20	2996	4065

5. САЛБАР ОФФИСУУД

Ханбогд

- ОНХТХХ-ээс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд болон хийгдэж буй ажлуудад салбар оффисын үүргийг сайн хийж гүйцэтгэсэн.
- ХБ-ийн алсын харааг тодорхойлох ажлын дараа орон нутгийн соёлын клубээр дамжуулан мэдээлэл түгээх ажил хийгдсэн ба төлөвлөгөөний гол бүрэлдэхүүний төсөл боловсруулсан.
- Орон нутгийн иргэдээс ургамлын үр худалдан авах ажлыг зохион байгуулсан.
- Жемри болон Эко Трейдийн хийх Гүний Хоолойн усны хэрэглээний зөвлөлгөөний материалуудыг бэлтгэсэн.
- Замын орчмын өрхүүдийн газрын зургийг хянасан. (10км)

Даланзадгад

- ОНХТХХ-ээс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд болон хийгдэж буй ажлуудад салбар оффисын үүргийг сайн хийж гүйцэтгэсэн.
- Орон нутгийн газар тариалан эрхлэгчдийг дэмжин, Даланзадгадаас гурван төрлийн, нийт 15,000кг ногоог Оюу Толгой ХХК-д нийлүүлэв.
- Эрүүл мэндийн байгууллагын техникийн чадавхийг үнэлэх ажилд оролцсон.
- Оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн оюутнуудыг шалгаруулав.

Манлай

- ОНХТХХ-ээс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд болон хийгдэж буй ажлуудад салбар оффисын үүргийг сайн хийж гүйцэтгэсэн.
- Манлай сумын Алсын харааг тодорхойлох ажлыг амжилттай зохион байгуулав.

- Орон нутгийн иргэдээс ургамлын үр цуглуулах ажлыг гүйцэтгэв.
- ОТ- Чойрын замыг сайжруулахад оролцов.

Баян-Овоо

- ОНХТХХ-ээс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд болон хийгдэж буй ажлуудад салбар оффисын үүргийг сайн хийж гүйцэтгэсэн.
- Баян-Овоогийн Алсын харааг тодорхойлох ажлыг амжилттай зохион байгуулсан
- БО-ын спорт заалын тендер зарлах ажлын талаар холбогдох орон нутгийн удирдлагуудтай хамтарч ажиллаж байна./зураг

6. ХАНДИВ ТУСЛАМЖ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Манай ОНХТХХ-ийн хандивийн комисс нь Өмнийн Говийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах, тогтвортой хөгжлийг дэмжсэн арга хэмжээг илүү санхүүжүүлэхийг эрмэлздэг билээ. 2010 онд Оюу Толгой төслөөс Ханбогд суманд 366,438,238.38 төгрөгийн, Даланзадгад суманд 10,250,000.00 төгрөгийн, Манлай суманд 145,885,200.00 төгрөгийн, Баян-Овоод 146,220,000.00 төгрөгийн, бусад сумдад 341,112,295.37 төгрөгийн хандив тусламж үзүүлсэн ба Өмнөговь аймгийн хэмжээнд 2010 онд нийт 1,009,905,733.75 төгрөгийн хандив тусламж үзүүлсэн байна.

Дизель түлшний тусламж

Оюу Толгой Компаниас Ханбогд, Манлай, Баян-Овоо сумыг сар бүр түлшээр хангадаг билээ.Түлш олгосноор сумын төвийн иргэд 24 цаг гэрэл цахилгаанаар хангагдаж байгаа. Үүний үр дүнд байгууллага аж ахуйн нэгж, айл өрхүүд техник хэрэгслээ бүрэн ашиглаж, иргэдэд үйлчлэх бүхий л үйлчилгээнд эрс ахиц дэвшил гарлаа. Иргэдийг мэдээллээр хангах, иргэд өөрсдөө интернет, тв-ээр мэдээлэл авах боломж бүрдсэн. 2010 онд Ханбогд суманд нийт 283,957,371.10 төгрөгийн, Баян-Овоо суманд нийт 146,220,000.00 төгрөгийн, Манлай суманд нийт 145,300,000.00 төгрөгийн, Ханхонгор суманд нийт 265,000.00 төгрөгийн түлш тус тус хандивласан байна.

“ГОВЬ ФЕСТИВАЛЬ-2010”-ыг зургаа дахь жилдээ ивээн тэтгэлээ

Оюу Толгой ХХК нь “Говь Фестивал -2010” арга хэмжээг зургаа дахь жилдээ ивээн тэтгэлээ. Уг фестивалд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд оролцож, үйлдвэрлэсэн бүтээгдхүүнээ сурталчлахын зэрэгцээ борлуулах, хамтран ажиллах түншээ олох боломжтой юм. Оюу Толгой ХХК энэхүү арга хэмжээний үеэр “Сэрсэн говь” сэтгүүл, сар бүр эрхлэн гаргадаг “Мэдээллийн хуудас”-ыг иргэдэд тарааж, тэдний сонирхсон асуултад хариулт өгч, санал бодлыг нь сонсов.



Үүний зэрэгцээ фестивалд хүрэлцэн ирсэн иргэдийг компанийн лого бүхий бүтээгдэхүүнээр урамшуулсан нь олны талархлыг хүлээсэн арга хэмжээ болсон юм. Хоёр хоног үргэлжилсэн “Говь фестиваль-2010” арга хэмжээнд оролцогсдыг арван номинациар байр эзлүүлсэн бөгөөд Оюу Толгойкомпани “Шилдэг сурталчилгаа” хийсэн аж ахуйн нэгжээр шалгарч, цом, өргөмжлөл, мөнгөн шагнал хүртлээ. Энэхүү арга хэмжээг Оюу Толгой төсөл 1,000,000 төгрөгөөр ивээн тэтгэсэн юм.

Баян багийн 1000 ботгоны баяр



Ханбогд сумын Баян баг нь 1000 ботго бойжуулсан түүхэн амжилтын баяраа гурав дахь удаагаа 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ёслол төгөлдөр тэмдэглэлээ.

Баярт Ханбогд сумын удирдлага, албан байгууллагууд, малчид, иргэд болон Оюу Толгой ХХК-ийн төлөөлөл оролцлоо. Уралдаан тэмцээнд амжилттай оролцож, малч ухаан, хичээнгүй хөдөлмөрөөрөө бусдыгаа хошуучилсан малчдаа шагналаа.

Үүнд:

-Тэргүүний залуу малчин өргөмжлөл, 200 мянган төгрөг, мөнгөн аяга:

Баян багийн малчин Х.Бадамгарав

-Тэргүүний залуу малчин өргөмжлөл, 100 мянган төгрөг, мөнгөн аяга:

Баян багийн малчин О.Мөнх-Очир, Р.Бадамдорж нар тус тус шагнагдлаа.



Баян-Овоо. Өндөр настан Ж.Бунтуу

Цагаан сарын баяр

Ханбогд сумын ЗДТГ, Соёлын төвтэй хамтарч 1-р сарын 31, 2-р сарын 01- ны өдрүүдэд цагаан сарын баярыг тохиолдуулан жилийн ном хурах уламжлалт арга хэмжээг зохион байгууллаа. Энэ ёслолын үеэр манай компаниас нутгийн өндөр настан Ө.Улцан, С.Хорол, Б.Тогтох, Ц.Асралт, Л.Цэрмаа нарт сэтгэлийн дэм өгч цагаан сарын тавгын идээг нь бэлэглэлээ. Үүнээс гадна Оюу Толгой төслийн хамт олон

Даланзадгад, Ханбогд, Манлай, Баян-Овоо нутгийн олондоо төмөр барс жилийн Сар шинийн баярыг тохиолдуулан говь нутгаас төрөн гарсан Монгол улсын алдарт гавьяатнууд болон 214 өндөр настнуудаа хүндэтгэн сэтгэлийн бэлэг гардууллаа.

Залуу гэр бүлийн 3 ихэр хүүхдэд тусламж

2009 оны 01 сарын 17-нд Өмнөговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт 3 ихэр хүүхэд мэндэлсэн. Ихрүүдийн аав, ээж Оюу толгой ХХК-д хандан туслалцаа хүссэний дагуу залуу гэр бүлд санхүүгийн дэмжлэг үзүүлж гурван ихрийг эрүүл өсч торниход шаардагдах нэмэлт тэжээл, сүүн бүтээгдэхүүн худалдан авахад зориулан сар бүр 270 мянган төгрөгийн тэтгэмжийг олгохоор шийдвэрлэлээ.

2010 онд нийт 3,600,000.00 төгрөгийн тусламж энэхүү гэр бүлд үзүүлсэн бөгөөд тэтгэмжийг 2012 оны 01 сарын 17-н буюу ихрүүдийг 3 нас хүртэлх хугацаанд олгохоор ихрүүдийн ээж Д.Оюунчимэгтэй гэрээ байгууллаа.



Энхбаатарын Мөнхзаяа, Мөнхтамир, Мөнхзул

Овоо тахилгын ёслолд хандив өргөө

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Ханбогд хайрхан, Мөнх-Овоо уулын тахилгын ёслолыг 2010 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Гэсэр сүмийн унзад лам Батмөнх тэргүүтэй 4 лам, Өмнөговь аймгийн Маанийн хийдийн лам С.Батхуяг нар уригдан ирж лус савдаг, хайрхан уулсаа баясган тэмдэглэв. Оюу Толгой ХХК-ийн ОНХТХХ хэлтэс Соёлын өв хөтөлбөрийнхээ хүрээнд уг ёслолд хүндэтгэл үзүүлэн оролцсон төдийгүй Ханбогд хайрханы тахилгын ёслолд 500,0 төгрөг Номгон, Баян, Гавилууд багуудын овоо тахилгын ёслолд нийт 900,0 төгрөгийн, Манлай сумын овоо тахилгын ёслолд 500,0 төгрөг тус тус хандив өргөлөө.

Оюу Толгой ХХК “Оюуны Спортыг Хөгжүүлэх Сан”-д таван сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ

Өмнөговь аймгийн Шатар даамны холбоо “Оюуны спортыг хөгжүүлэх сан” байгуулж, хадгаламжийн хүүгийн хуримтлалаар нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэн, говь нутагтаа оюуны спортыг хөгжүүлж, ирээдүйтэй шатарчин, даамчдыг бэлтгэх санаачлага гаргасан. Энэхүү санаачлагыг Оюу Толгой компани дэмжиж, уг санд таван сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ. Оюуны спортыг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэнд аймгийн Шатар даамны холбооны тэргүүлэгчид Оюу Толгой компанид талархал илэрхийлж, хүндэтгэлийн батламж гардуулан хадгалууллаа.

Баян-Овоо, Манлай сумдын Улаан Загалмай хороотой хүмүүнлэгийн үйлсэд хамтарч ажиллалаа

Оюу Толгой ХХК-ийн Орон нутгийн харилцаа тогтвортой хөгжил хэлтэс Баян-Овоо, Манлай сумдын Улаан загалмайн хороотой хамтарч Оюу Толгой төслийн хэрэгцээнд ашиглаж байсан монгол гэрийн эсгий дээвэр, туурга, бүрээс гэрийн мод, хөшиг, хөнжил, гудас, матрас зэргийг төслийн нөлөөллийн сумдын иргэдэд олгов. Ийнхүү нийт 11,336,600.00 төгрөгийн тусламжийн бараагаар 100 гаруй өрхийн амжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн бөгөөд Улаан загалмайн хороодын тусламжийн тогтвортой үйл ажиллагааг дэмжсэн ажил боллоо.

Өмнөговь аймгийн Стандартчилал хэмжилзүйн хэлтэст хөрөнгө оруулалт хийлээ

Өмнөговь аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэст усны тоолуурыг баталгаажуулдаг эталон төхөөрөмжийг шинээр худалдан авахад зориулж таван сая гурван зуун тавин мянган төгрөгийн (5,350,000.00) тусламжийг үзүүллээ. Ингэснээр Өмнөговь аймгийн төвийн айл өрх,

албан газруудад усны төлбөрийг задгайгаар тооцон төлүүлж байсныг өөрчилж, доголдлыг хэвийн болгоход жинтэй хувь нэмэр орууллаа.

Хандивын комисс

Өмнө Говийн Сайн дурын Хандивын Бодлогыг ахин хянаж үзсэний үндсэн дээр ОНХТХХ нь гурван ажилтнаас бүрдсэн Хандивын комиссыг байгуулсан . Комисс нь орон нутгаас ирсэн санал хүсэлтийг авч үзэн, компаний бодлоготой нийцэж байгаа эсэхийг хэлэлцээд, хэлтсийн ахлах менежерт зөвлөмж бэлдэнэ.

Бусад хандив тусламж

- Оюу Толгой сайтаас гардаг хаягдал модыг багийн дарга нар, сумын нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн нартай ярилцаж тусламж шаардлагатай иргэдэд тогтмол олгож байна. Хороо бууц сэлбэх, түлээ түлшинд нэмэр болгон хаягдал модыг харж хандах хүнгүй, хөдөлмөрийн чадваргүй, өндөр настан иргэд болон өрх толгойлсон эмэгтэй, олон хүүхэдтэй , хороо бууц муутай, зуданд нэрвэгдсэн өрхүүдэд олгодог.
- Гавилууд багийн засаг дарга малчиддаа дэмжлэг үзүүлэх үүднээс сайтын хаягдал дугуйг ашиглаж шинээр малын хороо барих хүсэлт гаргасныг дэмжиж 3 машин хаягдал дугуй олголоо. Үүний үр дүнд тус багийн 11 өрхийн өвөлжөө, хаваржаа хороо бууцыг засаж сайжруулсан байна.
- Оюу Толгой төслийн барилгын ажлын үе шатны удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг хариуцдаг (FLUOR) ФЛОУР ХХК-ийн ажилтан, албан хаагч нарын санаачлагаар Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсийн сумд болох Баян-Овоо, Ханбогд, Манлай сумын цэцэрлэгийн бяцхан иргэдэд шинэ жилийн бэлэг гардуулав. Мөн цэцэрлэгүүдэд тоглоом бэлэглэлээ.
- Өмнөговь аймгийн Хавдарын эсрэг төсөлд 1,000,000.00 төгрөг
- Өмнөговь аймгийн Малжуулах санд 50,000,000.00 төгрөг
- Өмнөговийн хахир хатуу зудны үеэр Мал хамгаалах санд Оюу Толгой төслөөс 90,207,000.00 төгрөг
- Аймгийн хөгжимт драмын жүжгийн дуучин н.Энхтуяагийн CD хэвлүүлэхэд 1,000,000 төгрөг
- Шинэ Ханбогд ТББ-аас зохион байгуулсан Говийн бүсийн гар бөмбөгийн тэмцээнд 600,000 төгрөг.
- Гашуун Сухайт боомтод Генератор суурилуулахад 69,392,787.28 төгрөг